



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 16 өдөр

Дугаар 4/131

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.1, Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.5 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий намрын баяр 2024 арга хэмжээнд оролцох зардалд зориулан 1 000 000 (нэг сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Шаардагдах зардлыг Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас гаргахыг нягтлан бодогч (Б.Нандин-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ц.БАТЦООЖ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХАМТ
ОЛНЫ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ.

№ 04

2024 он 09 сарын 16

Хурал 2024 оны 09 сарын 16 ны өдрийн 15 цагт Засаг даргын өрөөнд 80% ирцтэй хурал эхлэв.

ХЭЛЦЭХ АСУУДАЛ:

Хэнтий намрын баяр 2024 арга хэмжээнд оролцох, зарладын талаар

СОНССОН НЬ:

Ц.Батцоож: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Мөрөн сумаас Хэнтий намар 2024 арга хэмжээнд зориулан гаргах зардалын талаар ярилцан хэлэлцье.

Н.Намжилноров: Хэнтий намар 2024 арга хэмжээнд хэдэн төгрөг гарах вэ

Ж.Дашжамц: Хэдэн төгрөг болж байна хаанаас гархаа ярилцаад явах уу

Д.Эрдэнэцэцэг миний хувьд Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж болно

Б.Мягмаржав: Хэнтий намрын баяр 2024 зардал мөнгө хэдэн төгрөг болхыг тооцож гаргасан уу

Ц.Батцоож: Миний хувьд зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргая гэсэн бодолтой байна.

Н.Амармөрөн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлыг Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлж зарцуулах журамтай тул та бүхэн хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Г.Энхцэцэг би засаг даргын нөөцөөс гаргахыг дэмжиж байна

Н.Энхмягмар: миний хувьд санал нэг байна

Д.Ганцэцэг: би бас санал нэг байн

Намжилноров: За Засаг даргын нөөц хөрөнгөөс
гарах саналтай байна.

Б.Нандин-Эрдэнэ зардалыг тооцож үзсэн

Г.Энхцэцэг за Засаг даргын нөөцөөс гаргах саналыг зөвшөөрч байна уу саналыг хараад шийдвэр гаргах уу

Ц.Батцоож: Гаргах төсөв байгаа зөвлөлөөс шийдвэр гарвал захирамж гаргаад Хэнтий намрын баяр 2024 ын зардал гарнаа

Ж.Дашжамц: Засаг даргын нөөц хөрөнгөөс холбогдох зардлыг гаргах нь зөв байх.

Бусад гишүүд бүгд саналыг дэмжлээ

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Засаг даргын зөвлөлийн хуралд оруулсан Засаг даргын Хэнтий намрын баяр 2024 арга хэмжээний зардал гаргах саналыг хэлэлцэн зөвлөлийн хуралд оролцсон гишүүдийн 100% ийн саналаар 1.000.000 төгрөгийн зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахаар шийдвэрлэв

ТЭМДЭГЭЛ ХӨТӨЛСӨН:  Г.ЭНХЦЭЦЭГ